



Нью Проспект Аудит

Нягтлан болох бүртгэл, аудит, татвар, зөвлөх үйлчилгээ

2019 оны 03 сарын 29 -ны өдөр

№ 1/74

Улаанбаатар хот

Хараат бус аудиторын дүгнэлт

“Цемент Шохой” ХК болон түүний охин компанийн
Хувьцаа эзэмшигч, Төлөөлөн Удирдах Зөвлөл болон Хөрөнгө оруулагчдад:

Санхүүгийн тайлангийн аудит

Дүгнэлт

Бид “Цемент Шохой” ХК болон түүний охин компани (“Групп”)-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн томоохон бодлогуудын хураангуйг багтаасан тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, нэгтгэсэн санхүүгийн тайлан нь “Цемент Шохой” ХК болон түүний охин компани 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартад нийцүүлэн Сангийн яамнаас баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитгаа Аудитын олон улсын стандарт (АОУС)-ын дагуу хийсэн ба эдгээр стандартын дагуу хүлээх хариуцлагаа энэхүү тайлангийн “Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага” хэсэгт харуулсан. Бид Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөл (НБЕЗОУСЗ)-өөс гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Монгол Улсын Аудитын тухай хуулиар санхүүгийн тайлангийн аудитад тавигддаг ёс зүйн шаардлагын дагуу группаас хараат бусаар зохион байгуулсан бөгөөд Монгол Улсын хууль болон НБЕЗОУСЗ-өөс гаргасан дүрмийн шаардлагын дагуу тавигддаг ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн. Бидний олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж бид итгэж байна.

Аудитын гол асуудлууд

Тайлант жилийн санхүүгийн тайланд хийсэн аудитад хамгийн их ач холбогдолтой асуудлуудыг бид өөрсдийн мэргэжлийн үнэлэмжийг ашиглан аудитын гол асуудалд оруулсан. Бид санхүүгийн тайлангийн дүгнэлтийн хэлбэрийг сонгохдоо эдгээр асуудалд анхаарсан ба эдгээр асуудлын талаар тусад нь дүгнэлт гаргаагүй.

- Толгой компани болон “Цемент Шохой” ХК нь тайлант хугацаанд 6,000,000 ширхэг энгийн хувьцаа нэмж гаргасан.



Хараат бус аудиторын дүгнэлт (үргэлжлэл)

Санхүүгийн тайлангийн талаар Удирдлага болон Засаглах удирдлагын хүлээх үүрэг хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайлангуудыг СТОУС-д нийцүүлэн Сангийн яамнаас баталсан заавар, журмын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах үүрэг хүлээх бөгөөд алдаа, зальт ажиллагаанаас үүдэлтэй материаллаг алдаанаас ангид нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэхэд зайлшгүй шаардлагатай дотоод хяналтыг удирдлагаас тодорхойлох үүрэг хариуцлагыг хүлээдэг. Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага нь групп тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх чадамжийг үнэлэх ба группийг татан буулгах, үйл ажиллагааг нь зогсоохоос бусад тохиолдолд үйл ажиллагаатай холбоотой асуудал болон нягтлан бодох бүртгэлд тасралтгүй ажиллагааны зарчмыг баримтлах үүрэг хариуцлага хүлээдэг. Засаглах удирдлага нь группийн санхүүгийн тайлагналын процесст хяналт тавих үүрэг хариуцлага хүлээдэг.

Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Бидний зорилго санхүүгийн тайлангууд нь бүхэлдээ алдаа, зальт ажиллагааны үүдэлтэй материаллаг дүнгээр буруу илэрхийлээгүй талаар ул үндэслэлтэй баталгаа олж авах, өөрийн дүгнэлтийг багтаасан аудиторын тайлан гаргахад орших ба бид Аудитын Олон Улсын Стандарт (АОУС), Монгол Улсын Аудитын тухай хуулийн дагуу аудитаа гүйцэтгэсэн. Энэхүү стандарт нь биднээс нэгтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг алдаагүй илэрхийлэгдсэн талаархи зохистой нотолгоог олж авахын тулд аудитаа төлөвлөж гүйцэтгэх ба ёс зүйн шаардлагуудыг дагаж мөрдөхийг шаарддаг.

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн буруу илэрхийлэл нь алдаа, зальт ажиллагаанаас үүсч болох ба дангаараа юм уу нийтдээ материаллаг болж, санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллаг буруу илэрхийллийг санхүүгийн тайлангийн аудитад авч үзнэ.

Бусад хууль тогтоомж, зохицуулалтын шаардлагын талаарх тайлан

Группийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитыг манай компани гүйцэтгэсэн бөгөөд 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн зэрэгцүүлэх мэдээллийг уг аудитлагдсан санхүүгийн тайланд үндэслэсэн болно.

Хараат бус аудитын тайлан гаргахад оролцсон гэрээт ажлын партнеров нэр нь Д.Энэбиш болно.



Нью Проспект Аудит ХХК
Монгол Улс, Улаанбаатар хот
2019 оны 3 дугаар сарын 29-ний өдөр

Энэхүү тайлан нь аудитын тайлангийн өдөр буюу 2019 оны 3 дугаар сарын 29-ний өдөр өдрөөр хүчин төгөлдөр үйлчилнэ. Аудитын тайлангийн өдөр болон энэхүү тайланг хэрэглэх хугацааны хооронд тохиолдож болох аливаа тайлагналын үеийн дараах үйл явдал, нөхцөл байдал нь уг нэгтгэсэн санхүүгийн тайлан болон тодруулгад материаллаг нөлөө үзүүлж болох юм. Уг тайлагналын үеийн дараах үйл явдал, нөхцөл байдлын нөлөөллийг дээрх аудитын тайланд тусгаагүй болохыг анхаарна уу.

“ЦЕМЕНТ ШОХОЙ” ХК болон ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИ
 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх
 Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан

<i>(Мянган төгрөгөөр)</i>	<i>Тодруулга</i>	2018	2017
Хөрөнгө			
Эргэлтийн хөрөнгө			
Мөнгө түүнтэй адилтгах зүйлс	5	1,230,183	29,631
Дансны болон бусад авлага	6	34,060,864	33,664,779
Татвар, шимтгэлийн авлага	7	309,923	291,112
Бараа материал	8	18,236,640	17,020,843
Урьдчилж төлсөн зардал	9	1,288,880	300,026
Борлуулах зорилгоор эзэмшиж буй үл хөдлөх хөрөнгө	10	410,682	410,682
Эргэлтийн хөрөнгийн дүн		55,537,172	51,717,073
Эргэлтийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө	11	268,284,412	278,303,159
Биет бус хөрөнгө	12	5,673,791	5,754,085
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	13	-	293,984
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	14	287,514	-
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		274,245,717	284,351,228
Хөрөнгийн дүн		329,782,889	336,068,301
Өр төлбөр			
Богино хугацаат өр төлбөр			
Дансны өглөг болон бусад өглөг	15	8,093,179	8,752,022
Татвар, шимтгэлийн өглөг	16	15,108,268	13,871,622
Богино хугацаат зээл	17	17,165,473	31,657,879
Урьдчилж төлөгдсөн орлого	18	22,361,491	3,783,694
Нөөц	19	-	70,135
Богино хугацаат өр төлбөрийн дүн		62,728,411	58,135,352
Урт хугацаат өр төлбөр			
Урт хугацаат зээл	20	45,019,899	42,207,758
Байгалийн нөхөн сэргээлтийн нөөц	21	407,278	259,812
Хойшлогдсон татварын өглөг	32	1,484,689	483,687
Урт хугацаат өр төлбөрийн дүн		46,911,866	42,951,257
Өр төлбөрийн дүн		109,640,277	101,086,609
Өмч			
Хувьцаат капитал	22	287,684,089	287,084,089
Нэмж төлөгдсөн капитал	23	420,000	-
Дахин үнэлгээний нөөц	24	43,484,169	43,484,169
Эзэмшигчийн өмчийн бусад хэсэг		1,905,958	1,905,958
Хуримтлагдсан ашиг (алдагдал)		(113,351,604)	(97,492,524)
Өмчийн дүн		220,142,612	234,981,692
Өр төлбөр болон өмчийн дүн		329,782,889	336,068,301

Хавсаргасан тодруулга нь энэхүү тайлангийн саллигүй хэсэг болно.

“ЦЕМЕНТ ШОХОЙ” ХК болон ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИ
 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн
 Нэгтгэсэн ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан

<i>(Мянган төгрөгөөр)</i>	<i>Тодруулга</i>	2018	2017
Борлуулалтын орлого	25	51,727,409	62,990,400
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	26	(50,890,628)	(49,729,952)
Нийт ашиг		836,781	13,260,448
Борлуулалт, удирдлагын зардал	27	(3,245,830)	(4,866,320)
Бусад орлого	28	714,658	3,300,345
Бусад зардал	29	(2,597,069)	(7,451,777)
Үйл ажиллагааны ашиг (алдагдал)		(4,291,460)	4,242,696
Санхүүгийн орлого	30	175,191	4,294
Санхүүгийн зардал	31	(10,260,572)	(8,986,794)
Орлогын татварын өмнөх ашиг (алдагдал)		(14,376,841)	(4,739,804)
Орлогын албан татварын зардал	32	(1,002,871)	(483,697)
Цэвэр ашиг (алдагдал)		(15,379,712)	(5,223,501)
Бусад дэлгэрэнгүй орлого:			
Дахин үнэлгээний нөөцийн өөрчлөлт		-	-
Нийт дэлгэрэнгүй орлого (алдагдал)		(15,379,712)	(5,223,501)

Хавсаргасан тодруулга нь энэхүү тайлангийн саллигүй хэсэг болно.

“ЦЕМЕНТ ШОХОЙ” ХК болон ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИ
2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн
Нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

(Мянган төгрөгөөр)

	Хувьцаат капитал	Нэмж төлөгдсөн капитал	Дахин үнэлгээний нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	Өмчийн дүн
2017 оны 12 дүгээр сарын 31-ний өдрөөр	17,184,718	-	4,131,437	1,866,171	(92,038,074)	(68,855,748)
Эхний үлдэгдлийн залруулга	-	-	330,071	-	(230,949)	99,122
Залруулсан үлдэгдэл	17,184,718	-	4,461,508	1,866,171	(92,269,023)	(68,756,626)
Тайлант жилийн цэвэр ашиг(алдагдал)	-	-	-	-	(5,223,501)	(5,223,501)
Хувьцаат капиталын өсөлт	269,939,158	-	-	-	-	269,939,158
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	-	-	39,022,661	-	-	39,022,661
Өөрчлөлт	(39,787)	-	-	39,787	-	-
2017 оны 12 дугаар сарын 31- ний өдрөөр	287,084,089	-	43,484,169	1,905,958	(97,492,524)	234,981,692
2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөр	287,084,089	-	43,484,169	1,905,958	(97,492,524)	234,981,692
Эхний үлдэгдлийн залруулга	-	-	-	-	(479,368)	(479,368)
Залруулсан үлдэгдэл	287,084,089	-	43,484,169	1,905,958	(97,971,892)	234,502,324
Тайлант жилийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	(15,379,712)	(15,379,712)
Хувьцаат капиталын өсөлт	600,000	420,000	-	-	-	1,020,000
Охин компанид шилжүүлсэн хөрөнгийн дахин үнэлгээний нөөц	-	-	-	-	-	-
2018 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр	287,684,089	420,000	43,484,169	1,905,958	(113,351,604)	220,142,612

Хавсаргасан тодруулга нь энэхүү тайлангийн салиггүй хэсэг болно.

“ЦЕМЕНТ ШОХОЙ” ХК болон ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИ
2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн
Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(Мянган төгрөгөөр)

	2018	2017
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
<i>Мөнгөн орлого</i>		
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	66,029,797	59,783,269
Буцаан авсан албан татвар	82,380	91,272
Бусад мөнгөн орлого	140,766	718,943
<i>Мөнгөн зарлага</i>		
Ажилчдад төлсөн	(8,958,579)	(9,854,516)
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	(3,056,484)	(1,946,216)
Бараа материал худалдан авахад	(10,097,001)	(6,766,449)
Ашиглалтын зардалд төлсөн	(7,105,325)	(9,036,476)
Шатахуун, тээврийн хөлс, сэлбэг	(13,013,347)	(6,794,597)
Хүүний төлбөрт төлсөн	(8,409,598)	(7,833,566)
Татварын байгууллагад төлсөн	(1,425,447)	(2,123,064)
Даатгалын төлбөрт төлсөн	-	-
Бусад мөнгөн зарлага	(602,387)	(32,169,795)
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	13,584,775	(15,931,195)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
<i>Мөнгөн орлого</i>		
Хүлээн авсан хүүний орлого	18,613	4,271
<i>Мөнгөн зарлага</i>		
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(5,605)	-
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(4,506)	-
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	(15,967,470)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	8,502	(15,963,199)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
<i>Мөнгөн орлого</i>		
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	62,309,041	61,227,857
Хувьцаа гаргаснаас хүлээн авсан	1,013,063	-
Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг	291	880
<i>Мөнгөн зарлага</i>		
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	(75,714,813)	(29,411,327)
Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал	(307)	(16)
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(12,392,725)	31,817,394
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	1,200,552	(77,000)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	29,631	106,631
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,230,183	29,631

Хавсаргасан тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.